



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 7/74

Баян-Овоо

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 195 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам"-ыг хэрэгжүүлэн ажиллах Засаг даргын дэргэдэх захиргааны зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Зөвлөлийн

дарга	Д.Гэрэлмаа	(Засаг даргын тамгын газрын дарга)
Гишүүд	Д.Сүнжидмаа	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
	Д.Агаармандал	(Санхүү албаны дарга)
	Д.Батзориг	(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	М.Анаржин	(Хүнс, Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)
	М.Эрдэнэбулган	(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)
	Ц.Өлзийбат	(Хэсгийн төлөөлөгч)

2.Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах ажлыг зөвлөлдөн шийдвэрлэж хэрэгжилтэнд хяналт тавьж, холбогдох журмын дагуу ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

3.Үнэлгээний, устгалын, худалдан борлуулах асуудал хариуцсан комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/41 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД



010000195

Сумын Засаг даргын 20²⁴ оны... дугаар
сарын...ны өдрийн... дугаар захирамжийн
хавсралт



ҮНЭЛГЭЭ ТОГТООХ АЖЛЫН ХЭСЭГ

- Санхүү албаны дарга
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Нийгмийн бодлогын мэргэжилтэн

УСТГАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

- Байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Хэсгийн төлөөлөгч
- Хүнс, Жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн

ХУДАЛДАН БОРЛУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

- Засаг даргын тамгын газрын дарга
- Санхүү албаны дарга
- Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн